

Ийнхүү 1997оны 7-р сарын 1-ээс “Нэг улс, хоёр систем”, “Гонконг хүн Гонконгийг удирдана”, “Дээд хэмжээний өөртөө эрхт” гэсэн дотоод хүрээтэй, “БНХАУ-ын Гонконг”, “Батлан хамгаалах болон гадаад харилцаагаа хамаарахгүй байх гадаад хязгаартай бяцхан бүс нутаг оршин тогтнож эхэлсэн юм.

Ашигласан материал:

1. “Гуанмин жибао” сонины 1996 оны дугаарууд
2. Сладковский. М.И Китай и Англия. Москва. 1980.
3. “Бань юе тань” сэтгүүлийн 1993 оны 03.
4. Ипатова.А.С Патриотическое движение на юге Китая в 40-ые годы XIX в. Москва. 1976.

ӨМӨЗО-ны
50 жилийн ойд

Өвөр Монголын Өөртөө Засах
Орны Хөлөнбуйр аймаг.

Ч.Батцэцэг.

Хөлөнбуйр гэдэг нь Монгол улс, Өвөр Монголын нутаг дахь Хөлөн болон Буйр гэсэн хоёр том нуурын нийлсэн нэр юм. Өвөр Монголын Өөртөө Засах Орны /ӨМӨЗО/ зүүн хойд хэсэг, зүүн болоод зүүн хойд талаараа Хар мөрөн муж, урдуураа Хянган аймаг, хойд болон баруун хойгуураа Эргүнэ гол, Орос улстай, баруун болоод баруун урдуураа Монгол улстай тус тус хиллэдэг хилийн шугамын нийт урт 1700, 82 км, 250 мянган ам км талбайтай, 4 хот, 9 хошуу /түүний гурав нь өөртөө засах хоцуу/, засаг захиргааны төв нь Хайлар хот. Хайлар, Манжуур, Ягши, Залан зэрэг 4 хоттой. Нийт 255118 мянган хүн амтай, үүнээс монгол үндэстний хүн ам 18,54 мянга, ороочлон, солон, зүрчид, түнгүс гэх мэт бусад цөөнх үндэстний хүн ам 23,81 мянга байна.

Одоо Хөлөнбуйр аймгийн түүхийн хуудсыг сөхөж үзье. МЭӨ Ш зууны үед Байгал нуур орчмоос зүүн Монголын нутгаар нутаглаж байсан хори, түмэд, баргуд, буриад, ихрээд, түнгүс зэрэг ойн иргэд цөм Хүннүгийн нүүдэлчин аймгуудын холбоо болон гүрний захиргаанд багтаж байсан бөгөөд бүр эрт дээр үеэс монгол угсаатан Хөлөнбуйрын бүс нутагт аж төрж байсныг эртний Хятадын “Тан улсын судар”-т тодорхой өгүүлжээ. Үүнд: “Шивэй, хятан нар болон бусад.. нүүдэлчин

аймгууд сүрлэг том уулын ар хормойгоор Их Шивэй аймаг бусад овог аймгуудтай зэрэгцэн голын /Эргүнэ гол/ сав газраар суурьшиж байв. Тэр нь Түрэгийн зүүн хойд хилээр одоогийн Хөлөн нуур тахирлан зүүн тийш урсаж, баруун шивэйн хилээр нэвтэрч улмаар зүүнтээ Их Шивэй рүү урсан Мэнгу /Монгол/ Шивэйн хойгуур, шивэйн урдуур бууж зүүн тийш урсана...” гэжээ. Шивэйн олон аймгийн дунд Мэнгу Шивэй нарыг Онон, Хэрлэн, Туул гурван голын эхэн урсгалаар нутагласан уг монголчуудын өвөг дээдэс гэж үздэг.¹

Хөлөн нуурыг тойрон нутаглаж байсан Шивэй нарын зарим нь гэр-тэрэг, тэрэгт бургасан орд барьж байсны зэрэгцээ гэр зуурын хэрэгсэл сав суулгыг мод, зэс, төмрөөр хийдэг, мөн Нэлээд нарийн ур ухаан шаардсан эвэр нум үйлдэж, ноосон нэхмэлийг их уран нарийн сүлждэг байжээ. Шивэй нар мал, ан амьтаны /булга, буга, бодон, үнэг, нохой/ арьс ширийг элдэж боловсруулан хувцас хунар, олбог ширдэг хийдэг байсан ажээ. Шивэйн зарим аймаг зундаа хот сууринд зусаж, өвөлдөө нүүдэл хийж, зарим нь өвөл сууринд өвөлжиж, зун нүүж зусдаг, газар тариалан эрхэлж байсан баримтууд байдаг. Үүнээс үзвэл шивэй нарын олонхи нь эрхэлсэн ажлын эрхшээлээр заримдаа нүүдэлч, заримдаа суурьшмал амьдралтай байсан² гэж үзэх талтай.

Умард шивэйн есөн аймаг гэдэг нь Х зууны үед Хөлөн Буйраар нутаглаж байсан есөн татартай аймгийн тоо, нутаг дэвсгэрээрээ тохирч байдаг. ХП зууны үед татарууд бүгдээрээ Буйр нуур хавьд нутаг дэвсгэртэй болсон учраас тэдний үндсэн нутаг нь Буйр нуур гэдэг болжээ.

Хөлөн, Буйр хоёр нуур орчмын татарын нутаг нь мал адгуулан өсгөхөд маш зохистой, соргог өвс, цэнгэг устай, үр тариа, хөрс бэлчээрийн нөөц газар байсан тул тэр сайхан бэлчээрийг эзэлж авахын төлөө тэмцэл тулаан нэлээд үүсч байжээ. “Монголын нууц товчоо”-нд дурьдахдаа: Тэмүжин хүчээ яаран хуралдуулж тэдгээр аймгийг нэгдэхээс өмнө амжиж тайчиуд, дөрвөн нарыг Буйр нуурын орчим, хатагин, салжиуд нарыг хөлөн нуурын орчим тус тус цохив...Ван хан тэмүүжиний хүссэн ёсоор цэргээ авч хоёр этгээдийн цэрэг Хэрлэнд нийлж, тэндээс хөдлөн мордож Буйр, Хөлөний хооронд Хүйтэн гэдэг газар Жамухын цэрэгтэй байлдан бут цохисон тухай бичжээ. Хэнтийн нуруунаас эх авч Хар мөрөний сав газар хүртэл өргөжин тэлсэн Хөлөнбуйр нутаг нь монголчуудын зэр зэвсгийн агуулах, цэрэг эрсийн бэлтгэл сургууль хийдэг түшиц газар болж байв. Монгол угсаатан овог

аймгууд энэхүү Хөлөнбуйр нутгийн байгалийн нөхцөл байдлын давуу талыг ашиглан бүхий л талаар хүчээ сэлбэн хуримтлуулж, монгол угсаатныг нэгтгэж байсан түүхтэй. Эрт дээр үеэс монголчуудын эзэмшин нутаглаж байсан умар зүг байгал нуураас өмнө зүг Хятадын Их Цагаан хэрэм хүртэл, зүүн зүг Хянганы нуруунаас өрнө зүг Алтайн уулсыг өнгөртлөх уудам их нутаг нь “монгол нутаг”, “монгол газар” гэж нэрлэгдэх болжээ.³ Тэр үеэс өдгөө хүртэл Хөлөнбуйр нутгийн уул, хад, гол горхийн нэр энд түүхийн дурсгал болон хадгалагдан үлджээ. Хятадын “Тан улсын судар”-т “Ммэнгу Шивэй” нар одоогийн Эргүнэ голын зүүн сав газраар нутаглаж байсан тухай, Рашид-Ад-Диний “Судрын чуулган” гэх мэт олон сурвалж бичигт монгол угсааны овог, аймаг эргүнэ голоор нутаглажж байсан гэсэн мэдээллүүд байдаг.

Юан улсын үед Монгол нь Хятадын дотоод мужийн нэгэн адил хэдэн замд хуваагдаж байсан ба харин Өвөр Монголын нутаг нь Шанду, Ляодун, Кайюань, Данин зэрэг мужуудад хуваагдан захирагдаж байсан юм. Юан гүрний захиргаа Хятадад ХИҮ зууны хоёрдахь хагаст мөхсөнөөс хойш Монгол, Хятад хоёр улсын хил хязгаар Хятадын Цагаан хэрмийн араар зааглагдан тогтоогджээ. Монгол, Мин улсын хооронд цэрэг дайны үйл ажиллагаа нэлээд удаан хугацаагаар үргэлжилжээ. Мин улсын цэрэгт түрэгдэн Цагаан хэрэмийн ард гарсан монголчууд хүчээ нэгтгэн гурван чиглэлээр тэмцэж байв. Энэ үед Мин улсын засгийн газар зөвхөн цэргийн хүчээр монголчуудтай тэмцээд зогсохгүй худалдаа наймаа, харилцааны эдлэв арга хэрэглэж байсан ажээ. ХҮП зууны үед Монголын тусгаар тогтнол алдагдан Манжийн түрэмгийлэлд автаж байх үеэр Хаант Орос улс түүний умард хэсэг буриад болон Сибирийн нутгийг эзэмшиж эхэллээ. Энэ үед Хөлөнбуйрын нутагт амьдарч байсан Баргын Гантөмөр ноёны захирч байсан нутгийн зүүн болон өмнө хэсэгт Манжийн ноёрхол хүчтэй болж байхад мөн хойд хязгаарт нь Амар болон Байгалын арын нутгийг эзлэн эзэмшиж байсан оросууд ойрхон тулж иржээ. Гантөмөр ноён Манжийн захиргаанд орохыг хүссэнгүй эсэргүүцэн тэмцэж улмаар Оросоос тусалж магад хэмээн 1667 онд Оросын харьяат болон дагаар орсон байна. Ийнхүү Барга сайн дураараа Оросын эзэмшлийн нутагт нэгдэж, нутгийн хил хязгаар нь Их Хянганы нуруугаар Манж улстай хил нийлэх болжээ.⁴

Хаант Орос Чин улстай найрамдалт харилцаа тогтоохыг эрмэлзэн хилийн асуудлаар хийсэн анхны хэлэлцээр нь 1889 оны “Нэвчүүгийн гэрээ” бөгөөд түүний үр дүнд Чин улсын зүүн хойд хэсэг Оросын хил хязгаар гэдгийг тодорхойлж, Баргын нутгийг Манжид буцааж өгчээ. Харин Чин улсын засгийн газар, Хаант Оросын хооронд “Хөлөнбуйрын асуудал” хэмээх хэрэг үүсчээ. Найралт төвийн тавдугаар он буюу 1727 оны есдүгээр сард Орос, Чин улсын хилийн асуудлаар хоёр дахь хэлэлцээ хийсэн байна. 1730 оны үед Чин улсын засгийн газар ийш тийш тарж бутарсан бргын ард түмнийг цуглуулан Хөлөнбуйрт сум хошууны зохион байгуулалтын хуваарь хийснээр баргууд найман хошуунд багтаж, зарим хэсэг нь Хар мөрөн муж, Гирин, Мүгдэн зэрэг газарт суурьшжээ. манж нар Хөлөнбуйр, Хар мөрөн мужийн хязгаарыг сахин хамгаалж байсан монгол цэрэг, өрх айлуудыг хятадуудаар сольж, тэнд атар хагалбарлах ажлыг эхэлсэн байна.⁵ Харин Хөлөнбуйрын нутаг дэвсгэрт аж төрж байсан барга, монгол бусад үндэстэн Чингийн захиргааг удаан хугацаагаар дагахгүй, тэднийг эсэргүүцэн босч, үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хаа сайгүй хүчтэй өрнүүлсэн юм.

1911 оны 12 дугаар сарын 29-нд Жибзундамба хутагтыг монгол улсын хаан ширээнд өргөмжлөн, Монголын тусгаар тогтнолыг тунхаглав. Ийнхүү Монголын цагагчин гахай жилийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн илжээ. Хөлөнбуйр баргууд Их Хүрээнд ялсан хувьсгалыг дэмжиж, олноо өргөгдсөний 2 дугаар буюу 1912 оны эхээр зэвсэгт бослого гаргаж Чин улсын захиргааг хөөн зайлуулж тусгаар тогтнохоо зарлаж улмаар Их хүрээнд байгуулагдсан Монгол улсын засгийн газрыг зөвшөөрөн хүлээж дагаар орохоо илэрхийлж элч төлөөлөгчөө нийслэл Хүрээ рүү илгээж байв. Чин улсын ноёрхолд байсан бүх монголчуудыг нэгтгэх хөдөлгөөн өрнүүлснээр Ххөлөнбуйрын барга, дотоод монголын 49 хошууны 35 нь Монгол улсад нэгдсэн байна.⁶ Гэвч 1915 оны гурван этгээдийн Хиагтын хэлэлцээрээр Олноо өргөгдсөн Монгол улсаас салж “тусгай орон” болжээ.

Дундад Иргэн Улс/ДИУ 1915 онд Өвөр Монголын ихэнхи хэсгийг Халуун гол, Чахар, Суйюань гэдэг гурван онцгой орон болгосон байна. ДИУ-ын цэргийн эрхтэн Сюй Шучжэн 1919 оны эцсээр Гадаад Монголын автономи, Хөлөнбуйрын тусгай орныг устгаж, Хөлөнбуйрыг 1920 онд Хар мөрөн мужид захируулжээ. 1931 оны зун японы түрэмгийлэгчид Өдөр Монгол руу довтолж, 1932 онд

Манжуур, Өвөр Монголын зүүн хэсгийг эзэлж авлаа. Тэд эзэлсэн газартаа засаг захиргааны өөрчлөлт хийж, монголчуудын оршин суудаг муж хошуудыг хятадуудаас ялган зааглахыг оролдож, чуулган хошуу бүрт өөрийн зөвлөхийг томилон ажиллуулж байв. Тэд энэ нутгийг цэрэг ба цэргийн үйлдэрлэлийн хэрэгцээг хангах хүнс, түүхий эдийн чухал газар хэмээн үзэж байсан билээ. Японы түрэмгийлэгчид Өвөр Монголын баруун хэсгийг бас эрхшээлдээ оруулсан 1943 онд Хянганы дөрвөн мужийг “Хянганы ерөнхий муж” болгон өөрчлөв.⁷

Японыг эсэргүүцсэн Өвөр Монголын ард түмний 14 жилийн тэмцэл, Зөвлөлт-Монголын цэрэг дайчдын хамтын хүчээр 1945 онд Өвөр Монголыг японы булаан эзлэгчдээс чөлөөлсөн юм. 1946 оны 8 дугаар сарын 22-нд Хянган мужийн ардчилсан засгийн газарт захирагдах, Хөлөнбуйрын өөртөө засах засгийн ордныг байгуулж ажиллуулсан байна. Энэ талаар “Дунбэй жибао” сонинд нийтлэгдсэн Зүүн хойд Хятадын захиргаа хорооны 9 дүгээр бүгд хурлын мэдээлэлд дурьдахдаа: Хөлөнбуйрын өөрийн засгийг сэргээн тогтоох хүсэлтийг харгалзан Хөлөнбуйрын өөрийгөө захирах эрхийг сэргээн тогтоох ба орон нутгийн өөртөө засах засгийн газрыг байгуулах тухай шийдвэрийг батлав⁸ гэжээ. Зүүн хойд Хятадын чөлөөлөгдсөн нутаг дэвсгэр дээр Хөлөнбуйрын ард түмэнд өөртөө засах муж байгуулах бололцоо бий болсон боловч 1948 оны 1-р сард Хөлөнбуйрыг Монголын бүрэлдэхүүний аймаг болгосон байна. Хөлөнбуйр аймаг 1945 оны намар 400 000 Хоньтой, 100 000 орчим үхэртэй, 50 000 адуутай байсагн бол 1948 онд хонь нь 182 000, үхэр 16500, адуу 300 толгойгоор тус тус өссөн байв.⁹

1950 онд Хөлөнбур аймгийг Нунмөрөн аймагтай нийлүүлж Хөлөн-Нун аймаг болон өөрчилжээ. Харин 1953 онд Хянган аймгийн бүх шатны ардын төлөөлөгчдийн хурлаар Хянган аймгийг устгаж, Хөлөн-Нун аймгийг өөрчилж Хөлөнбуйр аймаг болон зохион байгуулсан байна. 1969 онд Хөлөнбуйр аймгийг ӨМӨЗО-ы захиргаанаас салгаж Хятадын зүүн хойд орны Хармөрөн мужийн харьяанд захируулсан боловч 1971 онд Хөлөнбуйр аймгийг ӨМӨЗО-ы захиргаанд буцааж шилжүүлжээ.

Өнөөгийн Хөлөнбуйр аймагт Эргүний зүүн хошуу, Эргүний баруун хошуу, Шинэ баргын зүүн хошуу, Хуучин баргын хошуу, Ацай хошуу, Орохоны өөртөө засах хошуу,

Эвенк үндэстний өөртөө засах хошуу, Мориндаваагийн Дагуур үндэстний өөртөө засах хошуу багтаж байна. Хөлөнбуйр аймаг бол Хятадын хамгийн умард хэсэг дэх олон үндэстний төвлөрөн суудаг бүсийн нэг.¹⁰ Хил хязгаарын Хөлөнбуйр аймагт эдийн засгийн нээлттэй бодлогыг хэрэгжүүлснээр “хойд хязгаарын үндэстний цөөнхийн нээлттэй туршилтын бүс” болсон юм.¹¹ Ингэснээр гадаад дотоодын олон газартай холбоо тогтоож, эдийн засаг, шинжлэх ухаан-техник, соёл урлаг, жуулчлалын салбарт хамтран ажилладаг, Ази, Европын их замыг нэвтрүүлсэн чухал газар болж байна.

Хөлөнбуйр аймаг нь гадаадын хөрөнгө оруулалтын гол цэг бөгөөд Орос, Америк, канад, Сингапур, Өмнөд Солонгос, Япон, Гонконг, Макао, Тайвань зэрэг 10 гаруй улс орронттой хөрөнгө оруулах тухай гэрээ хэлэлцээр хийж, хамтын ажиллагаагаа өргөжүүлж эхэллээ. Эл нутаг нь байгалийн унаган төрхөө хадгалж ирсэн цэнгэг ус, ой модны баялаг, хөрс бэлчээр, ашигт малтмалын ордоороо алдартай тул жуулчлалыг хөгжүүлэх бүрэн боломжтой ажээ.

Байгалийн нөөцийн хувьд ӨМӨЗО-ы нийт тариан талбайн 1/5-ийг, ой модны баялагаар 73 хувийг, усны нөөцийн мөн 73 хувийг тус тус эзэлдэг. Хөлөнбуйр аймаг тээвэр холбоо, агаарын дэд бүтцийг хөгжүүлэх талаар идэвхтэй ажиллаж байна. Хайларт нисэх буудал байгуулж, Бээжин, Тяньцзинь, Хөх хот, Далянь, Мүгдэн болон Оросын Чита мужид агаарын шугамыг нээжээ. Хөлөнбуйр аймаг ямааны ноолуур, модон эдлэл, малын ашиг шим, будаа, ургамлын тос, хүнсний ногоо, цахилгаан бараа зэргийг гадаадад гаргаж байна.

Хөлөнбуйр аймаг нь Монгол улсын хил залгаа Дорнод аймгийн Хавирга-Ар Хашаат, Баянхошуу-Өвдөг зэрэг газраар хилийн боомт нээж, хил худалдаа болон бусад талаар хамтын ажиллагаагаа хөгжүүлж байна.

Хөлөнбуйр нутгийн олон үндэстний ард түмэн өөрсдийн уламжлалт зан үйл, хэл яриа, бичиг үсгээ хадгалан, харилцан бие биенээ хүндэтгэн аж төрсөөр 21 дүгээр зууны босгонд ирлээ.

Ашигласан материал

1. “Монголын түүх судлалын түүвэр” Хөх хот, 1976 №1 х.29-р тал. /ӨМӨЗО-ы Хувьсгалт Хорооны монголын хэл утга, зохиол, түүх судлалын хүрээлэн /хятад хэлээр
2. БНМАУ-ын түүх 1 боть. УБ. 1961.х. 192-р тал

3. Мөн тэнд .х.223-р тал.
4. С.Д.Дылыков Өвөр Монголын ардчилсан хөдөлгөөн. УБ, 1957.х. 18-19-р тал.
5. “Хятад дахь монголчууд” УБ, 1996 .х. 34-р тал.
6. Л.Жамсран “Монголын цагаагчин гахай жилийн хувьсгал. УБ. 1996 .х. 17-р тал.
7. “БНХАУ-ын ӨМӨЗО” УБ, 1981 .х. 35-р тал.
8. “Дунбэй жибао” сонин 1946 11.10
9. “БНХАУ-ын ӨМӨЗО” УБ, 1981.х. 64-р тал.
10. “ӨМӨЗО-ы Их толь” 1994 он Хөх хот .Х. 49-р тал.
11. “Солонго” сэтгүүл 1995 №7 8-р тал.

Шүүмж Б.Лхамсүрэн. “Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол” зохиолын тухай.

В.В.Грайворонский С.Г.Лузянин

1980-аад оны сүүлч-90-ээд оны эхнээс, нэн ялангуяа 1990 оны ардчилсан тайван хувьсгал ялсанаас хойш Монголын нийгмийн амьдралын бүхий л хүрээг хамарсан радикал өөрчлөлтүүдийн явцад, XX зууны эхнээс авахуулаад Монголын шинэхэн түүхийг бүхэлд нь нэхэн ойлгох нарийн төвөгтэй, зөрчилтэй ажил үйлс чухал суурь эзлэв. Сүүлийн жилүүдэд монголын түүхчид, нийгэм судлаачид хуучирсан олон баримтлалыг хянан үзэх, түүхэн үйл явдлуудыг бодитой бөгөөд тал бүрээс нь тусган харуулах, хилс хэрэгт хэлмэгдсэн буюу мартагдсан зүтгэлтний ролийг үнэлэх талаар ихээхэн ажил хийжээ.

Энэ талаар гүйцэтгэсэн ажлын дотор Монголын Шинжлэх Ухааны Академийн Түүхийн хүрээлэнгээс эрхэлсэн “XX зууны Монгол” хэмээх эрдэм шинжилгээний том төсөл чухал байр эзлэнэ. Бидний шүүмж бичиж буй монголын эрдэмтэн ШУА-ийн гишүүн Б.Лхамсүрэнгийн бүтээл нь уул номын редактор М.Санждоржийн өмнөх үгэнд хэлсэнчилэн дээрхи төслийн эхний хэсэг бөгөөд гол төлөв монгол талын баримт сэлтийг үндэс болгосон байна.

Нэг сэдэвт зохиол нь хэмжээгээр харьцангуй том биш боловч, XIX зууны эцсээс өнөө үеийг хүртлэх маш урт хугацаа буюу бараг 100 жилийг хамарч монголын ард түмний төр улсаа сэргээхийн төлөө, тэмцлийн түүхийг 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын ялалтаас аваад 1994 онд баталсан